



БАГА БОЛОВСРОЛЫН НИЙГМИЙН УХААНЫ СУРГАЛТАД ЦАХИМ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН ЧУХАЛ БОЛОХ НЬ (IV-V ангийн “Хүн ба нийгэм” хичээлийн жишээн дээр)

Ц.Дэлгэрсайхан^а,
^а МУБИС-ийн Багшийн сургуулийн МХНУТ-ийн багш, доктор (Sc.D);
Холбоо барих зохиогч: Мэйл ID delgersaikhan@msue.edu.mn ORCID ID

Хүлээн авсан: 2026.02.25 Хянагдсан: 2026.04.03 Зөвшөөрсөн: 2026.05.18

Хураангуй

Энэхүү судалгааны ажил нь бага боловсролын нийгмийн ухааны сургалтад цахим хэрэглэгдэхүүний ач холбогдол, үр нөлөөг IV-V ангийн “Хүн ба нийгэм” хичээлийн жишээн дээр тодорхой шаардлага, шалгуураар судлан шинжилж, үндэслэл, нотолгоо бүхий санал, дүгнэлт боловруулахад оршино. Судалгааны хүрээнд Монгол Улсын БШУ-ны Сайдын 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/193 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтад ашиглах сургалтын нээлттэй материал, сургалтын интерактив контент, ээлжит хичээлийн цахим контентод тавих шаардлага” дахь “сургалтын цахим хэрэглэгдэхүүн”-д холбогдох шаардлагыг ашиглан, бага боловсролын “Хүн ба нийгэм” хичээлийн сургалтын цахим хэрэглэгдэхүүнд шинжилгээ хийхийг оролдлоо. Судалгаанд www.medle.mn сургалтын цахим платформд байршуулсан “Хүн ба нийгэм IV” ангийн 4 нэгж хичээлийн 32, “Хүн ба нийгэм V” ангийн 10 нэгж хичээлийн 64 ээлжит хичээлийн цахим контент, мөн энэ хоёр ангийн 25 теле хичээлд шинжилгээ хийлээ. Судалгааны үр дүнгээр бага боловсролын “Хүн ба нийгэм” хичээл, сургалтад Монгол Улсын түүх, соёл, уламжлал, үнэт зүйлс, даяаршлын тулгамдсан асуудлуудыг тусгасан, сурагчдын сонирхол, хэрэгцээнд нийцсэн, суралцахуйг дэмжсэн цахим хэрэглэгдэхүүнийг боловруулж, сургалтын агуулгыг баяжуулан, үр дүнтэй хэрэглэх шаардлагатай нь харагдлаа.

Түлхүүр үг

сургалтын хэрэглэгдэхүүнд тавих шаардлага, дижитал хэрэглэгдэхүүн, теле хичээл

Удиртгал

НҮБ-ын Хүүхдийн сан (ЮНИСЕФ)-гийн “Дижитал ертөнц дэх хүүхэд нас” (Дэлгэцийн цаг, дижитал ур чадварууд, сэтгэцийн эрүүл мэнд) 2025 оны тайлан илтгэлд дурдснаар, гучин жилийн өмнө дэлхий даяар дижитал холболт хэдхэн сая хүнд л хүрч үйлчилж байсан бол өнөөдөр дижитал хувьсгал дэлхий нийтийг хамарч,

бараг таван тэрбум хүн интернэтэд холбогдож байгааг онцлон тэмдэглэсэн байна. “Сүүлийн үеийн хүүхдүүд мэдээ орсон цагаасаа эхлэн цахим хэрэгсэлтэй төвөггүй харьцдаг болсон. Z болон альфа үеийн төлөөллүүдийг “цахим хүүхдүүд” ч хэмээн нэрлэж болно” (<https://www.unicef.org/mongolia/mn/article/tsahim-ayalal>). Европын 19 улс орны 20348 хүүхдийг хамруулсан, “EU Kids Online” төслийн судалгааг 2017-2019 онд хийж, хүүхдүүдийн дижитал ур чадварын түвшинг тодорхойлсон байна. Судалгаанд хамрагдсан орнуудад ихэнх хүүхдийн дижитал ур чадвар харьцангуй өндөр түвшинд байсан бөгөөд эдгээр улс орны хооронд онцын ялгаа бага байжээ. Хамгийн өндөр түвшний дижитал ур чадвартай хүүхдүүд нь Эстони, Норвеги, Финланд улсад ажиглагдсан байна. Учир нь эдгээр гурван улс нь 2000-аад оны эхнээс интернэтийг хамгийн эрт нэвтрүүлсэн орнуудын тоонд багтдаг бөгөөд хүүхдүүд төрсөн цагаасаа эхлэн боловсролын тогтолцоог оролцуулан, дижитал технологиор хүрээллүүлж ирсэн (UNICEF, 2025, р. 12-13) -тэй холбон тайлбарлажээ. Хүүхдүүд өдөр тутмын амьдралдаа дижитал технологитой харилцах боломж, нөхцөл их байх тусам өсөж торних явцдаа дижитал ур чадвараа хөгжүүлэх боломжууд нь нэмэгддэг ажээ. Үүгээрээ “дэлгэцийн цаг” ихэвчлэн хор хөнөөлтэй хэмээн үзэж, түүний ашиг тусыг орхигдуулж байгаа өнөөгийн маргаан мэтгэлцээний талбарт дээрх судалгааны үр дүнг сөргүүлэн тавьжээ.

Мэдээллийн технологийн эрин үед цахим сургалт хурдацтай хөгжих болсноор сургалтын хөтөлбөрийн агуулгыг сайжруулах, оновчтой төлөвлөх, зохион байгуулах хэрэгцээ шаардлага нэмэгдсээр байна. Ялангуяа хичээлийг үр дүнтэй болгох (*суралцахуйн үйлийн үр нөлөөг дээшлүүлэх*), сурагчдыг сэдэлжүүлэх, идэвхжүүлэх (*суралцагчдын танин мэдэхүйн идэвхийг нэмэгдүүлэх*), бүтээлч (*суралцагчдын мэдээлэлтэй ажиллах*) чадварыг хөгжүүлэхэд сургалтын цахим хэрэглэгдэхүүн чухал үүрэгтэй болох талаар олон улсын байгууллагуудын тайлан илтгэлд онцлон тэмдэглэж байна. “Бага ангийн хичээлүүдийн хувьд багшийн заах арга зүй бусад түвшнээс хамгийн өндөр буюу 75,2%-ийн үнэлгээтэй гарсан. СӨБ болон бага ангийн түвшинд сургалтын цахим хэрэглэгдэхүүн (танилцуулга / presentation, аудио болон видео контент гэх мэт) ашиглах байдал доогуур байсан бөгөөд дундаж оноо 60%-аас доош үнэлгээтэй гарсан байна” (MoES, IRIM, UNICEF, 2022, р.26).

Иймд хүүхдийн хөгжил, төлөвшилд чухал нөлөөтэй нийгмийн ухааны хичээл сургалтыг явуулахдаа сурагчдын хувийн болон нийгмийн хэрэгцээнд нийцсэн, сонирхол татсан агуулгаар баяжуулах, тэдний суралцахуйг дэмжсэн дасгал, даалгаврыг оруулах, цахим хэрэглэгдэхүүнийг оновчтой, үр дүнтэй ашиглах чиглэлээр сайжруулах шаардлага байна.

Нэр томьёоны тухайд

Юуны өмнө “сургалтын цахим хэрэглэгдэхүүн” гэж юу болох талаар авч үзье. Судалгааны бүтээлүүдэд англи хэлээр “**e-learning (electronic learning) materials, digital learning resources, digital learning materials, digital learning tools, e-learning tools, e-learning resource, digital educational resource**”, орос хэлээр “электронное обучение, техническое средства обучения” гэснийг ихэвчлэн “цахим сургалтын хэрэглэгдэхүүн”, “сургалтын цахим хэрэглэгдэхүүн” хэмээн орчуулан хэрэглэж байна.



Мөн “Мэдээлэл, харилцаа, холбооны технологи” (МХХТ) буюу “Information and Communication Technology”-ийг сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглах үүднээс “Мэдээлэл дамжуулах, хадгалах, бүтээх, солилцоход ашигладаг олон төрлийн технологийн хэрэгсэл, нөөц. Үүнд: компьютер, интернэт (вэб сайт, блог, мэйл), радио, телевиз зэрэг өргөн нэвтрүүлгийн технологи (аудио, видео тоглуулагч, хадгалах төхөөрөмж) болон суурин, хөдөлгөөнт телефон утас, утас, хиймэл дагуул, видео, онлайн хурлын төхөөрөмж зэрэг багтана” (Лувсандорж, Алтангоо, 2021, х.149) хэмээсэн тодорхойлолт ч байна.

Зарим судлаач “Е- сургалт (E- learning) гэдэг бол МХТ-ийг ашиглан, хэзээ ч (anytime), хаана ч (anywhere), хэн ч (anyone) өөртөө тохирох мэдлэг олж авах систем (Ганбат, 2009, х.56) гэсэн бол “Сургалтын цахим хэрэглэгдэхүүн гэдэг нь сургалтын дидактик шаардлагад нийцэхүйц боловсруулагдсан, компьютер болон бусад технологийн тусламжтайгаар суралцагчдад хүрч, сургалтад хэрэглэгддэг нэгэн төрлийн хэрэглэгдэхүүн юм. Технологи ашигласан сургалт нь уламжлалт сургалттай харьцуулахад маш их бэлтгэл (80%) шаарддаг (Цэдэвсүрэн, 2007) хэмээн тайлбарласан байна. Мөн “Е- сургалтыг цахим сургалт эсвэл вэбд суурилсан сургалт гэж нэрлэдэг-хичээлийг хаана ч, хэзээ ч интернэтээр дамжуулан, вэбд хандах хөтөч программ /дигитал нөөц материал ашиглан явуулдаг” (Нарантуяа, Ганбат, 2025, х.65) гэсэн байна.

ЮНЕСКО-гийн “Сургалтын хөтөлбөрийн нэр томъёоны тайлбар толь”-д “Электрон хэрэгслээр дэмжигдсэн, ялангуяа вэб болон компьютерт суурилсан багшлахуйн болон суралцахуйн мэдлэг, ур чадвар эзэмшихэд чиглэсэн бүх төрлийн сургалтын үйл ажиллагаа. Энэ нь танхимын болон бусад хэлбэртэй байж болох бөгөөд ихэвчлэн зайны болон виртуал сургалтын орчинд хамруулж болно (UNESCO, 2013, p.25) хэмээн тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, сургалтын төрөл хэлбэр, хэрэгслийг ашиглах, хэн удирдан явуулж, хэн хэрхэн оролцож байгаа байдлаар нь ангилдаг синхрон (synchronous) буюу онлайн (online -видео, аудио, чат, вебинар гэх мэт хэрэгсэл ашиглах) шууд, асинхрон (asynchronous) буюу офлайн (offline-хүлээлттэй буюу өөрөө удирддаг, өөрийн хурдаар суралцдаг - e-mail, CD, подкаст, блог, ярилцлага, хэлэлцүүлгийн форум, групп гэх мэт) гэх мэт вэбд суурилсан сургалтын хэлбэр, загварын алинд ч хамааралтай гэж ойлгож болохоор байна. Мөн “нүүр тулсан танхимын болон виртуал сургалт хосолсон, түүнчлэн асинхрон болон синхрон сургалт хосолсон, нүүр тулсан танхимын сургалтыг компьютер / технологи ашигласан сургалттай хослуулсан, танхимын хичээлийн нүүр тулсан суралцахуйг онлайн суралцахуйтай ухаалгаар нэгтгэсэн хэлбэр” (Нарантуяа, Ганбат, 2025, х.67) хэмээсэн “blended” (хосолсон горимын эсвэл уян хатан) сургалтад ч дээрх тодорхойлолт хамааралтай юм.

БШУ-ны Сайдын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/587 дугаар тушаалын хавсралт “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хэрэглэгдэхүүнд тавих шаардлага”-д “Сургалтын хэрэглэгдэхүүн: сургалтын арга зүйг хэрэгжүүлэхэд ашиглах техник хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, урвалж бодис, биет үзүүлэн, үзүүлэн, хэвлэмэл материал, сурах бичиг, зурагт үзүүлэн, дигитал хэрэглэгдэхүүн” хэмээн тодорхойлж, “1.3.8-д “Дигитал үзүүлэн: дуу авиа, дүрс, дүрс бичлэг, хөдөлгөөнт зураг, мультмедиа үзүүлэн” гэсэн байна.

Дээр дурдснаас үзвэл, тухайн контекстээс хамаарч өөр өөрөөр нэрлэх нь ажиглагдаж байгаа бөгөөд бид энэхүү судалгаандаа “цахим сургалт”-ын хэрэглэгдэхүүн гэхээсээ илүүтэйгээр багшийн хичээлээ заахад дэмжлэг болгох зорилгоор бүтээсэн, хэрэглэж байгаа “дигитал хэрэглэгдэхүүн” гэдэг утгаар “сургалтын цахим хэрэглэгдэхүүн” (digital learning materials/tools) хэмээн томъёолж, хэрэглэж байна.

Үндсэн хэсэг гарчиг 1. Бага боловсролын “Хүн ба нийгэм” ээлжит хичээлийн цахим контентын бүтэц, агуулга, арга зүйд хийсэн шинжилгээ

БШУ-ны Сайдын 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/193 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтад ашиглах сургалтын нээлттэй материал, сургалтын интерактив контент, ээлжит хичээлийн цахим контентод тавих шаардлага”-д “Ээлжит хичээлийн цахим контент - Тухайн ээлжит хичээлийн агуулгыг сурагчдад ойлгомжтой байдлаар дүрслэн үзүүлж, тайлбарлахад чиглэсэн, логик дэс дараалал, уялдаа холбоо бүхий цахим хэрэглэгдэхүүний багцыг ойлгоно” гэж тодорхойлжээ.

Уг тушаалын хавсралт дахь “6.1. Ээлжит хичээлийн цахим контентын бүтцэд тавих шаардлага”-ын “эхлэл, үндсэн, бататгал, нэмэлт” үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд болон тэдгээрийг бүрдүүлэгч дэд хэсгүүдийг энэхүү судалгаанд шалгуур болгон хэрэглэв. Ээлжит хичээлийн цахим контентын бүтцийн шинжилгээг хийхдээ “Хүснэгт 1”-ийн дэд бүрэлдэхүүн хэсэг бүрийг шалгуур болгож, түүнийг тоон үнэлгээгээр үнэлэх арга ашигласан. Ингэхдээ medle.mn цахим платформд байршсан “Хүн ба нийгэм-IV” ангийн 4 нэгж хичээлийн 32 ээлжит хичээл, “Хүн ба нийгэм -V” ангийн 10 нэгж хичээлийн 64 ээлжит хичээлийн цахим контентын бүтцийг судалгаанд хамруулав. Шалгуур бүрд 1-5 оноо өгч, тэдгээрийг дундажлан бодож, 5 оноог 100 хувь гэж үзэн, үнэлгээний хувийг гаргалаа. Үүнд:

Хүснэгт 1. Ээлжит хичээлийн цахим контентын бүтцийг үнэлсэн шалгуур, оноо, хувиар

Үндсэн бүрэлдэхүүн хэсэг	Дэд бүрэлдэхүүн хэсэг	Үнэлгээ /оноо/	Хувь (5=100%)
Эхлэл хэсэг	Хичээлийн агуулгыг сонирхон судлах сэдэл төрүүлсэн байдал	4.6	92%
	Тухайн сэдвийг судлах хэрэгцээ, шаардлага, хичээлийн зорилго, зорилтыг таниулсан байдал	2.6	52%
	Тухайн ангийн хүүхдийн нас сэтгэхүйн онцлог, мэдлэг, ойлголтын түвшин	2.7	54%
	Хичээлийн сэдвийн онцлогоос хамааран текст, зураг, дүрслэл, видео, интерактив гэх мэт хэлбэрүүдээр дүрслэгдсэн байдал	4.6	92%



Үндсэн хэсэг	Тухайн сэдвийн хүрээнд сурагчид эзэмших агуулга, нэр томъёо, ойлголт, мэдлэгийг тайлбарласан үндсэн мэдээлэл	4.9	98%
	Сурагчдын асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэх, хамтран ажиллах, харилцах, эргэцүүлэх чадварыг хөгжүүлэх зорилго бүхий үйл ажиллагааны заавар, дасгал, даалгавар, туршилт ажил	5.0	100%
Бататгал хэсэг	Хичээлээр судалсан агуулга, мэдлэг, ойлголт, нэр томъёо, ухагдахуунаа бататгах	4.2	84%
	Өөрийгөө шалгах, асуултад хариулах, мэдлэгээ хэрэглэх гэх мэт асуулт, даалгавар, үнэлгээний хувилбарууд	4.6	92%
Нэмэлт хэсэг	Суралцагчдын суралцах онцлог, танин мэдэхүйн өөр өөр байдал, эрэлт хэрэгцээг хангасан нэмэлт үйл ажиллагаа	4.8	96%
	Сурагчдын тухайн сэдвийг үргэлжлүүлэн бие даан суралцах, сонирхолтой мэдээлэл авах, хэрэглэх программ татах, үзэх, сонсох материалын эх сурвалж линк, унших текст, зураг, гэрийн даалгавар гэх мэт мэдээллийг багтаасан байдал.	4.5	90%

“Хүснэгт 1”-ийн үнэлгээнээс харвал, medle.mn цахим платформд байршсан хичээлүүд нь БШУ-ны Сайдын А/193 дугаар тушаалын хавсралт дахь “Ээлжит хичээлийн цахим контентын бүтцэд тавих шаардлага”-ыг сайтар баримталж боловсруулсан нь харагдаж байна. Шаардлагын “Эхлэл хэсэг” бүтцэд байхгүй “Хүрэх үр дүн” гэдгийг ээлжит хичээлийн цахим контентод оруулсан байгаа боловч энэ нь зорилго, зорилттойгоо төдийлөн уялдаа муутай, суралцагчдын эзэмшсэн байх мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн хүрээнд хэмжигдэхүйц, үнэлэгдэхүйц байдлаар томъёолоогүй байна. Мөн “Нэмэлт хэсэг”-т сурагчдын бие даан суралцах материалын эх сурвалж линкүүдийг дарахад зарим мэдээллийн эх сурвалж гарахгүй байгаа дутагдлыг цаашид анхаарууштай юм.

Ээлжит хичээлийн цахим контентын агуулгын хувьд дээрх хичээлүүд нь шаардлагын дагуу нэгжээр багцлагдсан ээлжит хичээлүүдээс бүрдсэн байхаар системтэй, сургалтын хөтөлбөр, сурах бичгийн агуулгатай нийцэхүйц байдлаар боловсруулсан нь зүйтэй байна. Мөн сурагчдын бие дааж ажиллах, мэдлэг бүтээх үйл ажиллагаанд үр ашигтай байхаар “асуудал шийдвэрлэх, бүтээлчээр сэтгэх, хамтран ажиллах, харилцах, эргэцүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны заавар, дасгал, даалгавар, туршилт ажил” хангалттай сайн тусгасан нь олзуурхууштай. Харин “нийгэм, ахуйн соёл, итгэл үнэмшил, нийгмийн үнэ цэнийг хүндэтгэх үзлийг төлөвшүүлэх” шаардлагын хүрээнд хэт судлагдахууны агуулгыг голлож, сурагчдын өдөр тутмын амьдралын бодит жишээ тохиолдлоос хол мэдлэг, ойлголтыг түлхүү тусгасан байдалд дүгнэлт хийж, цаашид сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

Арга зүйн хувьд “бие даан гүйцэтгэх дасгал, даалгавар, сорил туршилт, төслийн ажлуудын тавил нь танин мэдэхүйн болон ахуй амьдралтай холбоотой асуудал

шийдвэрлэх арга зүй”-д суурилсан байх шаардлагыг баримталсан нь ажиглагдав. Жишээ нь зураг дүрслэлийн олон хэлбэр, загвар, бүдүүвч, харьцуулан жиших, ангилах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг аргуудыг өргөн ашиглахын зэрэгцээ сурагч өөрийгөө үнэлэх жишиг даалгаврууд нь олон хувилбартай, сурагчдын танин мэдэхүй, эзэмшихүйн зүй тогтолд нийцэхүйц бүтээлч болсон байна. Харин шинжлэх ухааны нарийн төвөгтэй асуудлыг сурагчдын хөгжлийн онцлог, түүний шалгууртай холбож, аль болох элементарчлах шаардлагатай нь харагдлаа.

Үндсэн хэсэг гарчиг 2. Бага боловсролын “Хүн ба нийгэм” теле хичээлд хийсэн шинжилгээ

ЕБС-ийн IV-V ангийн “Хүн ба нийгэм” теле хичээлд шинжилгээ хийхдээ БШУ-ы Сайдын А/193 дугаар тушаалын II хавсралтын “Сургалтын нээлттэй материалд тавих ерөнхий шаардлага”, “Аудио, видеонд тавих шаардлага”-ыг баримтлав. Мөн теле хичээлүүдийг үзэж, дээрх шаардлагын хүрээнд үнэлгээ хийхдээ, “Теле хичээлийн үр дүнгийн судалгаа”-ны “Экспертийн үнэлгээний элемент, нарийвчилсан шалгуур” (MoES, IRIM, UNICEF, 2022, p.26)-ыг хэрэглэв.

Хүснэгт 2. Теле хичээлийн үнэлгээний элемент, нарийвчилсан шалгуур, оноо, хувиар

Үнэлэх элемент	Нарийвчилсан шалгуур	Үнэлгээ /оноо/	Хувь (5=100%)
Зорилго	Зорилго, зорилтоо танилцуулж буй байдал	4.2	84%
	Зорилго, зорилт тодорхой, ойлгомжтой байдал	4.1	82%
Агуулга	Тухайн хичээлээр судлах шинэ үг хэллэг, нэр томъёо ашиглаж буй байдал	3.8	76%
	Агуулгыг ахуй амьдралын асуудалтай холбосон байдал	4.7	94%
	Агуулгын багтаамж, оновчтой байдал	4.7	94%
	Агуулга нь цөм хөтөлбөр, сурах бичгийн агуулгатай нийцэж буй байдал	5	100%
Хэрэглэгдэхүүн	Хэрэглэгдэхүүний шаардлага хангасан байдал	3.6	72%
	Хэрэглэгдэхүүний төрөл, сонголт	3.7	74%
	Хэрэглэгдэхүүний ач холбогдол, ашиглаж буй байдал	3.8	76%
	Цахим хэрэглэгдэхүүн ашиглаж буй байдал	4.2	84%
Багшийн яриа	Сурагчдын насанд тохирсон хурд, өнгөөр ярьж буй байдал	4.1	82%
	Шинэ үг хэллэг, нэр томъёог тайлбарлаж өгч буй байдал	3.3	66%
	Сурагчийн насанд тохирсон үгийн сан хэрэглэж буй байдал	4.3	86%



Багшлах арга зүй	Хичээлийн эхлэл, үе шатуудыг уялдаа холбоотой төлөвлөж хэрэгжүүлсэн байдал	4.3	86%
	Хичээлийг сурагчдын сонирхол, хэрэглээтэй холбож, сэдэлжүүлж буй байдал	4.3	86%
	Хичээлийн цагийн оновчтой байдал	4.6	92%
Сурагчийн оролцоог дэмжсэн байдал	Багшийн хийсэн үйл ажиллагааг сурагч дагаж хийх боломжтой байдал	4.2	84%
	Сурагчдад бодох, эргэцүүлэх өөрийнхөө асуудлыг шийдэх боломж олгож буй байдал	4.6	92%

Medle.mn цахим платформд Хүн ба нийгэм IV ангийн 8 теле хичээл байршсан боловч “Сургууль дахь миний оролцоо” сэдэвт хичээл 2 удаа, Хүн ба нийгэм V ангийн хувьд 18 теле хичээл байгаа боловч “Монгол хүний ахуй амьдралын онцлог юу вэ?”, “Их Монгол улс” сэдэвт хичээлүүд мөн тус бүр 2 удаа давхардаж орсон байна. Энэ нь техникийн шинжтэй алдаа байж болно.

“Хүснэгт 2”-д байгаа шалгуур, түүнд харгалзах оноо, хувийг харвал, теле хичээл зааж буй багш нар тухайн хичээлийн агуулгыг сургалтын хөтөлбөр, сурах бичгийн агуулгатай нягт уялдуулсан нь тодорхой харагдаж байна. Түүнчлэн, агуулгыг амьдрал ахуйтай холбох, агуулгын багтаамжийг оновчтой тодорхойлох, сурагчдад бодох, эргэцүүлэх, асуудлыг шийдэх боломжийг олгохыг хичээж байгаа нь ололттой тал гэж үзэж байна.

Харин шинэ үг хэллэг, нэр томъёог тайлбарлаж өгч байгаа байдал, тухайн хичээлээр судлах шинэ үг хэллэг, нэр томъёог ашиглаж буй байдал нь учир дутагдалтай байна. Ялангуяа “оролцоо, шаньюй, хүн чулуун хөшөө, угсаатан, мэдээлэл, түүх, соёл, овог аймаг, нэрт зүтгэлтэн, алдартан, үйлчилгээний байгууллага” гэх мэт судлагдахууны онцлогтой үг хэллэг, ойлголт ухагдахуун, нэр томъёог тогтож сайн тайлбарлах байдал дутмаг байна. Энэ нь бага ангийн багш нарын түүх, нийгмийн хичээлийн онолын мэдлэг, ойлголт, чадвар сул байгаатай холбоотой байж болно. Учир нь бага ангид монгол хэл, математик хичээлийг голлон заахад анхаарч ирсэн буруу практик өнөө хэр ажиглагдсаар байгаад шүүмжлэлтэй хандаж байна.

БШУ-ы Сайдын А/193 дугаар тушаалын шаардлагын дагуу авч үзвэл, дээрх бүх хичээлд “видео мэдээлэлд дохионы хэл, бичвэр тайлбар агуулсан”, “аудио, видео нь сурагчийн мэдлэгийг баяжуулах, бүтээхэд дэмжсэн байх”, “ажиллах явцад түр зогсоох, дахин эхлүүлэх боломжтой байх” зэрэг шаардлагад бүрэн нийцсэн гэж үзэж байна. Харин багш нарын нэгэн хэвийн яриа нь “видео, аудионы дуу нь сурагчийн анхаарал сарниулахаас зайлсхийх, сонсоход тааламжтай байх” шаардлагад хэр нийцэж байгааг цаашид анхаарууштай. Ялангуяа, “Хүн ба нийгэм IV” ангийн бүх теле хичээлийг нэг багш дангаараа заасан бол “Хүн ба нийгэм V” хичээлийг өөр өөр багш дангаар заахаас гадна хамтарч, хосолж заасан нь шинэлэг байв.

Судалгааны үр дүн

Судалгааны үр дүнгээс харвал, ээлжит хичээлийн цахим контентын тухайд “Тухайн сэдвийг судлах хэрэгцээ, шаардлага, хичээлийн зорилго, зорилтыг таниулсан байдал”, “Тухайн ангийн хүүхдийн нас сэтгэхүйн онцлог, мэдлэг, ойлголтын түвшин” хэсгийн үнэлгээ нь харьцангуй доогуур буюу 52%, 54%-тай гарсан. Учир нь хичээлийн зорилго, зорилтуудыг ялгаатай, логик уялдаа холбоотой, оновчтой томъёолж чадаагүй, үндсэндээ ижилхэн томъёолсон байна. Мөн зорилго, зорилтыг зөвхөн мэдлэг, чадварын хүрээнд томъёолсон нь сургалтын агуулгыг сурагчдад эзэмшүүлэхийг урьтал болгосонтой холбоотой гэж үзэж болохоор байна. Ээлжит хичээлийн цахим контентуудыг залуу багш нар голчлон боловсруулсан нь тэдэнд дижитал ур чадвар сайн байгааг харуулж байна. Харин “Хүн ба нийгэм-IV” ээлжит хичээлийн цахим контентыг 100% ЕБС-ийн түүх, нийгмийн ухааны багш нар боловсруулсан бол “Хүн ба нийгэм -V” ээлжит хичээлийн цахим контентыг бага ангийн багш нарын багаас гадна мөн түүх, нийгмийн ухааны багш нар боловсруулсан байна. Өөрөөр хэлбэл, 6-10 настай хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, ялангуяа нийгэмшихүйн хөгжлийн онцлогийг харгалзах байдал дутмаг тусгагдсан нь ажиглагдлаа.

Теле хичээл зааж буй багш нарын тухайд олон жил багшилсан, заах арга зүй сайтай, туршлагатай гэдэг нь илэрхий боловч сурах бичгийн агуулгыг теле хичээлийн хэлбэрээр сурагчдад дамжуулах, сурах бичгийн агуулгыг цаасан дээр бичсэн байдлаар самбарт наах, сурах бичгийн зураг үзүүлэнг томсгосон байдлаар мөн самбарт нааж харуулах, унших, тайлбарлах зэргээр нэгэн хэвийн идэвхгүй үйлийг ихэвчлэн гүйцэтгэж байгаа нь цашид багшийн дижитал ур чадварыг сайжруулах шаардлагатайг илтгэж байна.

Хэлэлцүүлэг

Энэхүү судалгаагаар ээлжит хичээлийн цахим контент болон аудио, видео, теле хичээлд тавих шаардлага, шалгуурын хүрээнд зөвхөн сурагчдад хүрч буй “оролт” -ыг авч үзэж, сургалтын цахим хэрэглэгдэхүүн хэрэглэж буй өнөөгийн байдлыг тодорхойлохыг оролдсон. Өөрөөр хэлбэл, судалгааны үр дүн нь хэрэглэгчдэд хэрхэн хүрсэн үр өгөөж, чанарыг “гаралт” талаас нь цогцоор тайлбарлах боломж хязгаарлагдмал юм. Иймд бага боловсролын нийгмийн ухааны сургалтад цахим хэрэглэгдэхүүний хэрэглээний өнөөгийн бодит байдлыг цогцоор нь судлах зорилгоор нийгмийн ухааны хичээлийн онцлогтой тусгай шаардлага, шалгуурыг боловсруулж, бага ангийн багш нарын хичээлд сууж, ажиглалт хийх, багш нартай фокус бүлгийн ярилцлага хийх, сурагч, түүний эцэг эх, асран хамгаалагч нараас судалгаа авч, дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

Дүгнэлт

Энэхүү судалгааны ажлаар бага боловсролын нийгмийн ухааны сургалтад цахим хэрэглэгдэхүүний ач холбогдол, үр нөлөөг IV-V ангийн “Хүн ба нийгэм” хичээлийн жишээн дээр тодорхой шаардлага, шалгуураар судлан шинжилж, судалгааны үр дүнд үндэслэн, дараах санал, дүгнэлтийг дэвшүүлж байна. Үүнд:



- “Хүн ба нийгэм” хичээлд цахим хэрэглэгдэхүүн боловсруулж, хэрэглэхийн өмнө тухайн хичээлийн сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж дахь “суралцахуйн зорилт”, “суралцахуйн үйл ажиллагаа”, “хэрэглэгдэхүүн”-ий уялдаа холбоог нарийвчлан судлах нь чухал юм. Мөн эдгээр элемент сурах бичигт хэрхэн туссан байгааг шинжилж үзэх шаардлагатай. Иймээс багш нар суралцахуйн зорилт, үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн шаардлагатай уялдаа, арга зүйг сайн ойлгож, цахим хэрэглэгдэхүүнээ үүнд нийцүүлэн төлөвлөх нь сурагчдын сургалтын үр дүнд шууд эерэг нөлөө үзүүлдэг.
- Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс 2023 онд боловсруулсан “3-17 настай хүүхдийн хөгжлийн шалгуур, үзүүлэлт” дэх “Бага боловсролын 6-10 настай хүүхдийн нийгэмшлийн хөгжлийн шалгуур, үзүүлэлт”-ийг судалж, сургалтын цахим хэрэглэгдэхүүнийг боловсруулах, хэрэглэхэд анхаарах нь зүйтэй байна.
- Бага боловсролын “Хүн ба нийгэм” хичээлийн хувьд бага ангийн багш нар түүх, нийгмийн ухааны онол, арга зүйн мэдлэг боловсролоо дээшлүүлж, Монгол Улсын түүх, соёл, уламжлал, үнэт зүйлс, даяаршлын тулгамдсан асуудлуудыг тусгасан, сурагчдын сонирхол, хэрэгцээнд нийцсэн, суралцахуйг дэмжсэн цахим хэрэглэгдэхүүнийг боловсруулахад санаачилгатай, бүтээлч эрэл хайгуул хийх нь зүйтэй. Ялангуяа энэ тал дээр мэргэжлийн судлаач, эрдэмтдийн санал, зөвлөгөөг авах нь үр дүнтэй гэж үзэж байна.
- Судалгааны явцад багш нар ихэвчлэн гадаадын дүрс бичлэг, дуу авиа, хөдөлгөөнт зураг, мультимедиа үзүүлэнг сургалтад ашиглаж байгаа нь ажиглагдлаа. Энэ нь үндэсний онцлогтой дижитал үзүүлэнг сургалтад ашиглах гэхээр “зохиогчийн эрх”-ийн асуудал үүссэнтэй холбоотой байж болно. Иймд бага ангийн багш нар дижитал хэрэглэгдэхүүнийг дангаар боловсруулахад хүндрэл, бэрхшээлтэй тул БШУЯ, Цахим боловсрол хариуцсан хэлтэс, Боловсролын мэдээллийн технологийн төв зэрэг холбогдох газрууд анхаарч, тодорхой дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

Ном зүй

1. Боловсрол, Шинжлэх Ухааны Яам. Мэдлээ / Цахим контент. Retrieved from <https://www.medle.mn>
2. Боловсрол, Шинжлэх Ухааны Яам & Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан. (2022). Сургуулийн менежмент, технологи, манлайлал (Ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтны сургалтын гарын авлага). Улаанбаатар: Би Си Ай.
3. Боловсролын сургалтын байгууллагын удирдлагын системд тавих шаардлага / А/111 тушаалын нэгдүгээр хавсралт, Боловсрол, Шинжлэх Ухааны Яам (2022).
4. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтад ашиглах цахим сурах бичигт тавих шаардлага / А/193 тушаалын нэгдүгээр хавсралт, Боловсрол, Шинжлэх Ухааны Яам (2021).
5. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтад ашиглах сургалтын нээлттэй материал, сургалтын интерактив контент, ээлжит хичээлийн цахим контентод



- тавих шаардлага / А/193 тушаалын хоёрдугаар хавсралт, Боловсрол, Шинжлэх Ухааны Яам (2021).
6. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хэрэглэгдэхүүнд тавих шаардлага / А/587 дугаар тушаалын хавсралт, Боловсрол, Шинжлэх Ухааны Яам (2023).
 7. Ганбат, Х. (2009). Багшийн хөгжилд *Е- сургалт чухал болох нь*. “Боловсрол судлал” боловсролын хөгжлийн онол, арга зүйн сар тутмын сэтгүүл. № 2009/04 (50), х.56-58.
 8. Нарантуяа, С., Ганбат, Д. (2025). Дээд боловсролын дижитал шилжилт, онлайн боловсролын асуудалд: олон улсын туршлага, чиг хандлага (судалгааны тойм). Улаанбаатар: Арилдал.
 9. Ministry of Education and Science & Independent Research Institute of Mongolia & United Nations Children’s Fund. (2022). *Assessment of Effectiveness of Tele-Lessons*. Ulaanbaatar: UNICEF.
 10. Суралцахуйн удирдлагын системд тавих шаардлага / А/111 тушаалын хоёрдугаар хавсралт, Боловсрол, Шинжлэх Ухааны Яам (2022).
 11. United Nations Educational, Scientific and Cultural Organization International Bureau of Education. (2013). *Glossary of Curriculum Terminology*. Geneva: UNESCO-IBE.
 12. United Nations Children’s Fund. (2025). *Childhood in a Digital World (Screen time, digital skills and mental health)*. Florence: UNICEF Innocenti.
 13. Лувсандорж, Ц., Алтангоо, О. (2021). Цахим сургалтын гарын авлага (Цахим сургалт, цахим хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүй, зөвлөмж). Улаанбаатар.
 14. Түмэнцэцэг, Б., Нямжав, Ц., Намжилдагва, Р. (2016). Бага боловсролын сургалтын цахим хэрэглэгдэхүүн бүтээх арга зүй боловсруулж туршсан үр дүн. МУБИС-ийн боловсролын онол, арга зүйн “Лавай” эрдэм шинжилгээний бичиг, №14, х.130-139.
 15. Цэдэвсүрэн, Д. (2007). Сургалтын цахим хэрэглэгдэхүүн боловсруулах онол, арга зүй (“Мэдээлэл харилцааны технологийг сургалтын үйл ажиллагаанд ашиглах нь” сургалт, семинарын РРТ танилцуулга.)



THE SIGNIFICANCE OF DIGITAL LEARNING RESOURCES IN PRIMARY SOCIAL STUDIES EDUCATION (A case study of the “Human and Society” subject in grades IV–V)

Delgersaikhan.Ts^a,

^aSc.D., associate professor, Teachers School, MNUE;

Corresponding author: Мэйл ID delgersaikhan@msue.edu.mn  ORCID ID

Abstract

This study investigates the significance and impact of digital learning resources in primary social studies education, conducting a systematic analysis of the “Human and Society” curriculum for Grades IV–V through rigorous evaluative criteria. Grounded in the requirements for “educational digital learning resources” stipulated in Order A/193 (May 21, 2021) by Mongolia’s Minister of Education and Science - Requirements for Open Educational Materials, Interactive Learning Content, and Digital Content for Regular Lessons in General Education Schools—the research analyzed 96 digital content modules from the www.medle.mn platform (32 lessons across 4 units of “Human and Society IV” and 64 lessons across 10 units of “Human and Society V”), supplemented by analysis of 25 televised lessons. Findings reveal a critical need to develop culturally responsive digital learning resources that integrate Mongolia’s history, culture, traditions, and values with global perspectives, align with students’ cognitive and motivational needs, and enhance effectiveness in primary social studies.

Keywords

requirements for instructional materials, digital learning resources, tele- lesson.
